



ОРХОН АЙМГИЙН
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 03 сарын 27 өдөр

Дугаар 1118

Баян-Өндөр сум


Мөнгөн дэмжлэг үзүүлэх
тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2009 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 53/45 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсад олон улс, тив, дэлхийн спортын тэмцээн, наадмыг зохион байгуулах, санхүүжүүлэх журам”-ын 4.3 дахь заалт, аймгийн Засаг даргын 2026 оны 03 дугаар сарын 20-ний өдрийн А/262 дугаар захирамжийн хавсралтын 1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ази тив, улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох тамирчдад зарцуулагдах төсвийг хавсралтаар баталсугай.


2. Хавсралтын дагуу санхүүжилтийн гэрээ байгуулж, хяналт тавьж ажиллахыг спортын тэмцээн, наадмын бодлогын хэрэгжилт, зохион байгуулалт, тайлагналт хариуцсан мэргэжилтэн (Д. Дашбаатар)- үүрэг болгосугай.

3. Мөнгөн дэмжлэгт зарцуулагдах 6,000,000 (зургаан сая) төгрөгийг зохих журмын дагуу нэмэлт санхүүжилтийн зардлаас гаргаж, гэрээний дагуу шилжүүлэг хийхийг ерөнхий нягтлан бодогч, аж ахуйн албаны дарга (Б. Золзаяа)-д зөвшөөрсүгэй.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ, СПОРТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА  Э. ЛХАМСҮРЭНБААТАР



Биеийн тамир, спортын газрын даргын
2026 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн
03 дугаар тушаалын хавсралт



ТЭМЦЭЭН, УРАЛДААНЫ МӨНГӨН ДЭМЖЛЭГТ ЗАРЦУУЛАГДАХ
ТӨСӨВ

№	Шийдвэрийн нэр, дугаар, огноо	Спортын төрөл	Зардлын нэр	Хүний тоо		Нэг бүрийн үнэ	Бүгд дүн (төгрөгөөр)
				Тамирчин	Дасгалжуулагч		
1	2	3	4	5	6	7	8
1	Засаг даргын 2026 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/262 дугаар захирамж	Улаанбаатар хотод зохион байгуулагдах Боксын Ази тивийн аварга шалгаруулах тэмцээн	Оролцох зардал	3	-	1,000,000	3,000,000
2		Баянхонгор аймагт зохион байгуулагдах U17 насны Улсын аварга шалгаруулах Волейболын тэмцээн	Оролцох зардал	2 баг	-	1,500,000	3,000,000
Төсвийн нийт дүн:							6,000,000

----oOo----

